



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/322

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын  
хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/424 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/141 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Саннилайф” ХХК-тай байгуулсан “Хороодын иргэний танхимд компьютер, принтер, ширээ, сандал /БГД 8, 9, 10, 13, 22 дугаар хороо/ худалдан авах” УБЗАА-ЗСХ-2019/007 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Баянгол дүүргийн 8, 9, 10, 13, 22 дугаар хорооны Иргэний танхимд нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /М.Энхболд/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000990

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 19 өдрийн 182 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	О.Нармандах	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн сургалт, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	С.Эрдэнэчимэг	Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/
	Я.Одгэрэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн